

ТАНИЛЦУУЛГА

“Сургалтын төлбөрийн хэмжээ, зардлын норматив шинэчлэн батлах тухай” хамтарсан тушаалын төслийн талаар

Цагдаагийн албаны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.3-т “Энэ хуулийн 17.1-д заасан төв нь албаны нохой ашиглах болон Галт зэвсгийн тухай хуулийн 10.4-т заасан болон гэрээт харуул хамгаалалтын сургалтыг төлбөртэй зохион байгуулж болно.” гэж, мөн зүйлийн 17.4-т “Энэ хуулийн 17.3-т заасан сургалтын төлбөрийн хэмжээг дотоод хэргийн болон санхүүгийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран тогтооно.” гэж заасныг үндэслэн “Сургалтын төлбөрийн хэмжээ, зардлын норматив батлах тухай” Хууль зүй, дотоод хэргийн сайд, Сангийн сайдын 2018 оны А/14/16 дугаар хамтарсан тушаалаар харуул хамгаалалтын чиглэлийн албаны нохой ашиглах, иргэний болон харуул хамгаалалтын зориулалттай галт зэвсэг эзэмших, ашиглах, хадгалах, аюулгүй ажиллагааны болон гэрээт харуул хамгаалалтын сургалтын төлбөрийн хэмжээ, зардлын нормативыг баталсан.

Цагдаагийн байгууллагаас улсын хэмжээнд сүүлийн 3 жилийн байдлаар “Иргэний болон харуул хамгаалалтын зориулалттай галт зэвсэг эзэмших, ашиглах, хадгалах, аюулгүй ажиллагаа” сэдэвт сургалтыг 2021 онд 14 удаа зохион байгуулж, 1546 иргэнийг хамруулж (232,013,800 төгрөг), 2022 онд 29 удаа зохион байгуулж, 1401 иргэнийг хамруулж (181,023,033 төгрөг), 2023 оны эхний 9 сарын байдлаар 21 удаа зохион байгуулж, 630 иргэнийг хамруулж (100,340,600 төгрөг), “Гэрээт харуул хамгаалалтын ажилтан” бэлтгэх сургалтыг 2021 онд 2 удаа зохион байгуулж, 119 иргэнийг хамруулж (46,043,790 төгрөг), 2022 онд 4 удаа зохион байгуулж, 360 иргэнийг хамруулж (45,726,790 төгрөг), 2023 оны эхний 9 сарын байдлаар 4 удаа зохион байгуулж, 587 иргэнийг хамруулж (110,421,613 төгрөг)-ийг тус тус төсөвт төвлөрүүлэн ажилласан.

“Сургалтын төлбөрийн хэмжээ, зардлын норматив батлах тухай” Хууль зүй, дотоод хэргийн сайд, Сангийн сайдын 2018 оны А/14/16 дугаар хамтарсан тушаалаар иргэний болон харуул хамгаалалтын зориулалттай галт зэвсэг эзэмших, ашиглах, хадгалах, аюулгүй ажиллагааны сургалтын төлбөрийн хэмжээг 150,000 (нэг зуун тавин мянга), гэрээт харуул хамгаалалтын сургалтын төлбөрийн хэмжээг 199,260 (нэг зуун ерэн есөн мянга, хоёр зуун жар) төгрөгөөр тогтоосон билээ.

Сүүлийн жилүүдэд өргөн хэрэглээний бараа, бүтээгдэхүүний үнийн өсөлттэй холбоотойгоор дээрх зардал нь хүрэлцдэггүй, тухайн төлбөрийн хэмжээг тогтоож байх үед буюу 2018 онд инфляцийн түвшин 6.5 хувь, ам.долларын ханш 2390.79 төгрөг байсан бол одоогийн байдлаар инфляцийн түвшин 13.8 орчим хувьд хүрч, ам.долларын ханш 3485.00 төгрөг болж тус тус өссөн нь одоо мөрдөж байгаа сургалтын зардлын хэмжээтэй харьцуулахад нийгэм, эдийн засгийн нөхцөл байдал, зах зээлийн бодит үнэ ханштай нийцэхгүй байгаа бөгөөд сургалтын төлбөрийн хэмжээ, зардлын нормативыг шинэчлэн батлах болон гэрээт харуул хамгаалалтын давтан сургалтын төлбөрийн хэмжээг тогтоох гэх зэрэг зайлшгүй хэрэгцээ шаардлага үүссэн тул “Сургалтын төлбөрийн хэмжээ, зардлын норматив шинэчлэн батлах тухай” Хууль зүй, дотоод хэргийн сайд, Сангийн сайдын хамтарсан тушаалын төслийг боловсрууллаа.

Дээрх сургалтын төлбөрийн хэмжээ, зардлын нормативыг шинэчлэн баталснаар улсын төсвөөс нэмэлт санхүүжилт шаардагдахгүй бөгөөд сургалтын үйл ажиллагаанд зарцуулах зардлыг зах зээлийн үнэ ханштай нийцүүлж, бодитой тогтоосноор иргэд, олон нийтэд олгож буй сургалтын чанар, үйл ажиллагаа сайжирна гэж үзлээ.